# МХЗЭ-ИЙН ТӨВ ХОРОО,МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОРОО,УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА,БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМ, ШҮҮХ ЯАМНЫ ХАВСАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ.

1979 оны 11 дугаар сарын 29 ны өдөр. | ТЗ-ны 1990 ... 140 ... | Улаанбаатар хот.

№ 69/ Ү /295/83/331/

" Гэр бүл,эрүүл ахуйн сургууль" байгуулах тухай.

Гэр бүлийн дотор социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх залуу гэр бүлд аж байдлаа зохион байгуулах үр хүүхдээ хүмүүжүүлэхэд нь туслах,ахуйн соёл нэвтрүүлэх зорилгоор ТОГТООХ НЬ:

I. Гэр бүл эрүүл ахуйн сургуулийн удирдах зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга - Цолмон /МХЗЭ-ийн Төв Хорооны 2-р нарийн бичгийн дарга/

Орлогч дарга нарт
- Дамдин /Шүүх яамны орлогч сайд
- Жамбал/ Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга/
- Жамбаа /Эрүүлийг хамгаалах яамны орлогч сайд/
- Хэнмэдэх /Монголын эмэгтэйчүүдийн хорооны орлогч дарга/

Нарийн бичгийн дарга нарт
- Дашдэндэв/Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны Иргэний гэр бүлийн хэлтсийн дарга/
- Минжүүр /Шүүх яамны Иргэний гэр бүл нотариотын хэлтсийн дарга/
- Оюун / Хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга /

Гишүүдэд
- Тогтохжаргал/Шүүх яамны хэлтсийн дарга/
- Уртнасан /МХЗЭ-ийн Төв Хорооны Үзэл сурталын хэлтсийн эрхлэгч
- Улаан / Монгрлын эмэгтэйчүүдийн хорооны ажилтан/

- Цасчихэр /Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хороны 2-р нарийн бичгийн дарга/
- Жанчив /Соёлын яамны хэлтсийн дарга/
- Доржханд /Хотын урчуудын салбарын эрхлэгч/
- Бор /МУИС-ийн багш,дэд эрдэмтэн/
- Нямбуу /ШУА-ийн социологийн хүрээлэнгийн ажилтан,дэд эрдэмтэн/
- Лхагваа /Ариун цэвэр гэгээрлийн ордны дарга /

2. Гэр бүл-эрүүл ахуйн сургуулийн удирдах зөвлөлийн дэргэд соёл хүмүүжлийн ажил хариуцсан доорхи секцийг I979-80 оны хичээлийн жилээс эхлэн байгуулсугай.

а/ Хууль зүйн секц

Секцийн дарга - Тогтохжаргал/Шүүх яаманд хэлтсийн дарга/

Орлогч дарга - Батсүх /Гавьяат хуульч/

Нарийн бичгийн дарга - Цэдэндамбаа /Хотын хуулийн зөвлөлгөө өх газрын дарга/

Гишүүдэд
- Будханд /Хуулийн дунд сургуулийн захирал/
- Хандсүрэн / МУИС-ийн багш,
- Авирмэд / МУИС-ийн багш,дэд эрдэмтэн

б/ Соёлын секц

Секцийн дарга - Жанчив / Соёлын яаманд хэлтсийн дарга/

Орлогч дарга - Мөнхдорж / Драмын театрын найруулагч/

Нарийн бичгийн дарга - Батнасан / ХГЗ-ийн соёлын хэлтсийн ажилтан/

Гишүүдэд
- Гантөмөр / гавьяат жүжигчин /
- Чулуун / Ардын жүжигчин /
- Очирбат / Гавьяат жүжигчин /
- Цэдэнбал / Циркийн хөгжөөн баясгагч/
- Литап -"-
- Сэлэнгэ / Драмын жүжигчин /
- Жагдаг / Филормоны жүжигчин/уран уншигч/

в/ Дүрслэх урлагын секц

Секцийн дарга - Доржханд /Хотын урчуудын салбарын эрхлэгч/

Орлогч дарга - Цэрэнпил /Хэвлэл чимэглэлийн үйлдвэрийн дарга/

Нарийн бичгийн дарга - Бүтэмж / Зураач /

Гишүүдэд: - Ванчиг -"-
Алтанхуяг -"-
- Гэрэл -"-

г/ Гэр бүл-эрүүл мэндийн секц

Секцийн дарга - Ч.Лхагва /Ариун цэвэр гэгээрлийн ордны дарга/

Орлогч дарга - Цэрэнжэгмэд /Ариун цэвэр гэгээрлийн ордны хүүхэд залуучуудын эрүүл ахуйн сургалтын арга зүйч/

Нарийн бичгийн дарга - Б.Шижирбаатар/Анагаах ухааны дээд сургуулийн эх барих эмэгтэйчүүдийн тэнхимын багш дэд эрдэмтэн

Гишүүдэд - З.Лувсандавга/ЭНХЭШ Хүрээлэнгийн захирал,дэд эрдэмтэн/
- Эрдэнэжав /Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газрын байцаагч/
- Энхдалай / Хэвлэлийн нэгдсэн редакцын ажилтан/
- Цэндсүрэн / Хүүхдийн клиникийн төв эмнэлгийн их эмч,дэд эрдэмтэн/

д/ Сурган хүмүүжүүлэх секц

Секцийн дарга - Бор / МУИС-ийн багш,дэд эрдэмтэн/

Секцийн нарийн бичгийн дарга - Чүлтэмжамц / УБДС-ийн багш,доктор/

гишүүдэд - Санжжав / УБДС-ийн багш ,доктор /
- Лувсандэнцэв/ Сурганы хүрээлэн /
- Дуламсүрэн /48-р сургуулийн орос хэлний багш /

е/ Гэр бүл-ахуйн соёлын секц

| | | |
|---|---|---|
| Секцийн дарга | - Нямбуу | / ШУА-ийн социалогийн хүрээлэнгийн ажилтан дэд эрдэмтэн/ |
| Нарийн бичгийн дарга | - Баясгалан | / Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн ажилтан/ |
| Гишүүдэд | - Лувсанцэрэн | / ШУА-ийн социалогийн хүрээлэнгийн фолософийн тасгийн эрхлэгч |
| | - Очирсүх | / Баянгол рестораны дарга/ |
| | - Шагдарсүрэн | / Хувцас загварын зохион бүтээгч/ |
| | - Балдандорж | / Худалдааны техникумын багш/нийтийн хоолны инженер технологч/ |
| | - Галсан | / гавьяат тогооч / |

А. Гэр бүл эрүүл ахуйн сургуульд заах хичээлийн программыг зөвшөөрч түүний дагуу хичээлийг сайн бэлтгүүлж чанартай явуулж байхыг гэр бүл,эрүүл ахуйн сургуулийн зөвлөл /н. Цолмон/-д даалгасугай.

Б. Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн соёлжих танхимыг"Гэр бүл ахуйн соёлын зөвлөлгөө өх газар болгон өргөтгөн түүний ажлыг Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөл,Иргэний гэр бүлийн хэлтсээс хамтран удирдан явуулж байсугай.

В. Эрүүл ахуйн сургуулийн зөвлөл,секц,гэр бүлийн ахуйн соёлын зөвлөлгөө өгөх газрын ажиллах журмыг батласугай. /хавсралт № 2/

Г. Хичээл хүмүүжлийн ажилд шаардагдах зардлыг МХЗЭ-ийн Төв Хороо,хотын Гүйцэтгэх захиргаанаас гаргаж байхаар тогтоосугай.

Д. Бичсэн лекц ярианы сэдвийн болон хичээл заасан цагийн хөлсийг багш нарт олгож байхаар тогтоосугай.

Е. Сургуулийн элсэлтийг зохион байгуулалттай явуулах ба цугларалтыг хариуцаж байхыг Улаанбаатар хотын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хороо,эмэгтэйчүүдийн зөвлөлд даалгасугай.

Ё. Хичээлийг эмнэлэг гэгээрлийн ордонд явуулж байсугай.

Ж."Гэр бүл,эрүүл ахуйн сургууль"-ийн хичээлийн материалаар 1980 онд багтаан товхимол хэвлүүлэхийг хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны Иргэний гэр бүлийн хэлтэс /н.Дашдэндэв/-т даалгасугай.

МХЭЭ-ийн Төв Хорооны I-р нарийн бичгийн дарга Л.ТҮДЭВ

Монголын эмэгтэйчүүдийн хорооны дарга С.УДВАЛ

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга С.МӨНХЖАРГАЛ

Эрүүлийг Хамгаалах Яамны сайд Д.НЯМСОР

Шүүх яамны сайд Б.ЧИМИД

# ГЭР БҮЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛ, СЕКЦ, КАБИНЕТИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Сургуулийн зөвлөл, секц, кабинетийн үндсэн зорилго нь залуу гэр бүл охид хөвгүүдэд улс төр, онол, гэр бүлийн ахуйн соёл, практикийн асуудлаар ойлголт өгөх ЗХУ болон социалист бусад орнуудын социализм коммунизм байгуулалтын үеийн гэр бүлийн ахуйн соёл, ёс суртахууны баялаг туршлагаас байнга эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

Гэр бүл, эрүүл ахуйн сургуулийн ажлыг Шүүх яам, Эрүүлийг хамгаалах яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа, МХЗЭ-ийн Төв Хорооны товчоо, Монголын эмэгтэйчүүдийн хорооны тэргүүлэгчдийн хамтарсан хурлын тогтоолоор батлагдсан зөвлөл удирдана.

1.Гэр бүл, эрүүл ахуйн сургууль батлагдсан программын дагуу жил бүрийн 11-р сараас дараа оны 5-р сарыг хүртэл хичээллэнэ.

2.Зөвлөл нь хичээлийн программ төлөвлөгөө зохиож,хийсэн ажлынхаа тайланг дараа оны 5-р сарын сүүлийн хагаст сонсогчиддоо тайлагнана.

3.Сургуулийн сургалт, хүмүүжил, бэлтгэл хангах, өдөр тутмын ажлыг зохион байгуулалтын ажил хариуцсан секц гардан удирдана.

4.Зөвлөлийн хурлыг хичээлийн жилд 3 удаа, секцүүдийн

хурлыг сар тутам хийж ажил төрлийн асуудал хэлэлцэнэ.

5.Зөвлөл нь секцүүдийг зохион байгуулж төлөвлөгөөт ажлыг графикийн дагуу хийлгэж, хийсэн дүнгийн тухай мэдээлэл авч байна.

6.Секцийн ажлыг хамтарсан хурлын тогтоолоор батлагдсан ахлагчид удирдана.

7.Гэр бүлийн ахуйн соёлын сургуулийн элсэлтийг жил бүрийн 10-р сарын 20-ны дотор Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хороо,эмэгтэйчүүдийн зөвлөл хариуцаж тусгай мэргэжлийн дунд болон их дээд сургуулиудын оюутан сурагч нийслэлийн ажилтан залуучуудын дунд явуулна.

8.Гэр бүлийн ахуйн соёлын сургуультай холбогдох программ үзүүлэн үнэмлэх, элсэлтийн урилгыг хэвлүүлэхийн зэрэгцээгээр лекцын сэдвүүдийг гарын авлага, товхимол болгон хэвлүүлнэ.

9.Гэр бүлийн ахуйн соёлын сургууль нь өөрийн ажлын салбар нэгж болох гэр бүл, ахуйн соёлын кабинетын ажлыг ерөнхий удирдлага, мэргэжилтэн, ухуулга сурталчилгааны хэрэгсэлээр хангаж ажиллана.

10.Гэр бүлийн ахуйн соёлын сургуулийн зөвлөл секцүүд зааврын дагуу ажлаа явуулахад харъяалах яам, дээд байгууллагууд боломжоор хангаж сургалтын болон сургалттай холбогдох материал, мэргэжилтний туслалцаа үзүүлж гэр бүлийн ахуйн соёлын сургуулийн сургалтыг цаашид боловсронгуй болгоход байнга саналаа

5.Гэр бүлийн ахуйн соёлын кабинет нь гэр бүлийн ахуйн соёл, эрүүл ахуй, гоо зүй, хууль эрхийн мэдлэг, олгохтой холбогдсон ном хэвлэл, ах дүү орнуудын туршлагаас суралцахад тусламж болох ном хэвлэлийн орчуулга "Гэр бүлийн ахуйн соёлын сургуулиас" гаргасан гарын авлага, товхимол, зураг, санамж, эмчийн зөвлөлгөө зэргээр зөвлөлгөө авагчдад үйлчилж, судлуулах буюу биечлэн зааж сургах ажлыг хийнэ.

6.Кабинет нь ажлаа жил улирал сараар төлөвлөж үр дүнгий нь тухай бүр нь гаргаж холбогдох газруудад мэдээлж ажиллана.

-------oo0oo-------

# ГЭР БҮЛИЙН АХУЙН СОЁЛЫН СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН ПРОГРАММ

## I.Гэр бүл-хайр дурлал-аз жаргал

а/хайр дурлалын тухай яриа;
/үерхэл,нөхөрлөл,шохоорхол, хайр дурлал/

б/гэрийн эзэн эзэгтэйн үүрэг хариуцлага;

в/гэр бүлийн аз жаргалын нууц;

г/хүний мөс... /баян Итгэлт, өвгөн Болд, халзан Доной Отелло Яго нартай уулзах/.

## 2.Зочлох зочлуулах ёсон

а/мэндлэх тухай;

б/найрын ширээ яаж засах вэ?

в/та зочлуулж чадах уу? /дугуй ширээний яриа/.

г/шог үзэгдэл;

## 3.Гэр бүлийн нийгмийн үүрэг

а/гэр бүл, нийгмийн үүрэг;

б/гэр бүлийн хоёр үндсэн чанар /нэг талаар бие хүний олон зүйлийн амин хэрэгцээ шаардлагыг хангагч, хэрэглүүр, нөгөө талаар нийгмийн үйл явцад нөлөөлөгч хэрэглүүр/

в/амин хувийн эрх сонирхлыг нийгмийнхтэй хослох нь социалист гэр бүлийн үндсэн шинж;

г/гэр бүл-Хүний нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн голомт;

д/гэр бүл-Өв тэгш хүмүүжилтэй ариун сайхан ёс суртахуун зан үйлстэнийг төрүүлэгч эх булаг;

е/ариун цагаан хөдөлмөр-Гэр бүлийн аз жаргалын үндэс;

4.Хүүхдийн хүмүүжилд эх эцгийн үүрэг, хариуцлага

а/хүүхэд түүний сэтгэхүйн онцлог;

б/хүүхдийг хүмүүжүүлэхэд эцэг эхээс гаргаж байгаа алдаа;

в/яагаад? яагаад? яагаад? хуульч, сурган хүмүүжүүлэгчдийн дугуй ширээний яриа;

5.Архи амьдралын дайсан

а/эмчийн зөвлөлгөө;

б/шог ба плакат зургийн үзэсгэлэн;

в/хайран!хайран! хайран! дугуй ширээнии яриа /эмч, хуульч, авто техникийн хэргийн шалган байцаах газрын ажилтан, сурган хүмүүжүүлэгч оролцоно;

6.Өрхийн төсөв

а/эзэн хичээвэл заяа хичээнэ /өрхийн төсвийн тухай/; эдийн засагчийн яриа.

б/хадгаламжийн ач холбогдол;

в/Юмханаар юм хийж нүдлэн хамгаалъя /зарчмын лозунтай холбож дугуй ширээний яриа/.

г/хямд үнэтэй материалаар хувцас хийх тухай;
/Хувцасны загвар,мода үзүүлэх/ Санал авч олонхийн сайшаал хүлээсэн хувцасыг их дэлгүүрт 14 хоног эсгүүрчин гаргаж эсгүүлэх, оёдлын үйлдвэрүүдэд захиалга авахуулах;

7. Бэлгийн хүмүүжил

а/бэлгийн хүмүүжил бол коммунист хүмүүжлийн бүрэлдэхүүн хэсэг мөн;

б/бэлгийн хүмүүжлийг ойлгох эмзэг биологи, гоо зүй, үзэл суртлын үндсүүд;

в/гэрлэлт, насны харьцаа;

г/бэлгийн хүмүүжил ба эрүүл мэнд;